



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР
ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2022 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 30

Хэрлэн сум

Төрийн албаны тэргүүний ажилтан
тэмдгээр шагнуулах тухай

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 5.7, 3.8, 3.8.3, 2013 оны 71 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны тэргүүний ажилтан тэмдгээр шагнах журам”-ын 3.1.2, 3.2-т заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн албанд олон жил үр бүтээлтэй ажилласан Баян-Овоо сумын Засаг даргын тамгын газрын дарга Борнойн Сарантуяа, Санхүүгийн албаны дарга Содномдоржийн Наранцэцэг, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга Раяагийн Оюунчимэг нарыг “Төрийн албаны тэргүүний ажилтан” тэмдгээр шагнуулахаар дэмжиж Төрийн албаны зөвлөлд уламжилсугай.

2. Шагналд нэр дэвшсэн төрийн албан хаагчдын шагналын материалыг Төрийн албаны зөвлөлд хүргүүлэхийг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ш.Эрдэнэжаргал/-д даалгасугай.

ДАРГА

Ж.ГАНБААТАР